



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР  
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн өргөн  
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442273  
Цахим шуудан: info@bayankhongor.gov.mn  
Цахим хаяг: www.bayankhongor.gov.mn

2022.06.09 № 2/143

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ Г

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2022 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн ажлын тайлан, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, дүгнэх хуудасны хамт хүргүүлэв.

Хавсралт <sup>205</sup>..... хуудаастай.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

615221434

## БАЯНХОНГОР АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 06 дугаар сарын 06

Номгон

Аймгийн Засаг даргын тамгын газар нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны А/14 дүгээр захирамжаар баталж, 2,0 сая/төг, аймгийн ИТХ-аас 7.700.000 төгрөгийг төсөвлөн 12 зорилтын хүрээнд 29 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилт 70 хувьтай байна.

### 1.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах ажлын хүрээнд:

Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллах, авлига, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас Авлигатай тэмцэх газарт төрийн байгууллагуудын албан хаагчдыг соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулж, хамтран ажиллах талаар хүсэлт хүргүүлж, тус газраас 2022 оны 2 дугаар сарын 9-ний өдөр “Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдол”, “Авлигатай тэмцэх чиглэлээр соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын туршлага” сэдвийн хүрээнд төрийн захиргааны болон үйлчилгээний 53 байгууллагын дарга, удирдлага, төсөв санхүү хариуцсан нийт 307 албан тушаалтанд сургалт мэдээллийг хийж, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн.



Аймгийн хэмжээнд иргэдийн хамгийн ихээр үйлчлүүлж төрийн үйлчилгээ авдаг албан тушаалтнууд болох "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийн 8 албан хаагчдад "Ард түмэнд үйлчлэх зарчим ба авлига ашиг сонирхлын зөрчил", "Төрийн албан хаагчийн харилцаа ба ёс зүй" сэдвээр 2022 оны 05 дугаар сарын



30-ны өдөр сургалт зохион байгуулж мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн.



Аймгийн 20 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон 31 байгууллагын дарга хүний нөөц, программ хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд **"Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"**-ийн талаар мэдээлэл өгч танхимын сургалтыг нийт 104 албан хаагчид зохион байгууллаа.

Тус арга хэмжээг АЗДТГ-ын Хяналт шинжилгээний үнэлгээний хэлтэстэй хамтран 19 сэдвийн хүрээнд 13 албан хаагч мэдээлэл хийж тэдний мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн.




Аймгийн хэмжээний нийт, сум байгууллагуудын дунд **“Авлигын эсрэг манлайлал”** аяныг жилийн хугацаатай зарлан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Аяны хүрээнд:

АТГ-аас ирүүлсэн телевизийн богино хэмжээний 14 шторк, хэвлэн олшруулах 6 төрлийн материалууд, ФМ, радиогийн 14 зөвлөгөө мэдээллийг сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж 59 байгууллагын 1630 төрийн албан хаагч, 3560 иргэдэд үзүүлж 1208 удаа олон нийтэд хуваалцсан байна. Мөн 73 групп, 61 пэйж хуудсанд байршуулсан.



Мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 14 төрлийн 64 зурган мэдээлэл, инфографик 183 ширхэг, 3 төрлийн гарын авлага



1873 ширхгийг олшруулж 5 мянга гаруй иргэнд тарааж тус тус сурталчилсан байна.

Мөн тус аяны хүрээнд төрийн 68 байгууллагуудын болон сумдын ИТХ-ын дарга нараас бүрдсэн нийт 2205 албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх талаар баталгаа гаргуулан хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан. Мөн АЗДТГ-ын нийт албан тушаалтан болон сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нараар авлигаас ангид байх баталгаа гаргуулан баталгаажуулж хувийн






хэргүүдэд нь хавсаргаж ажиллалаа.

Мөн Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд хамгийн олон сонсогчтой дэлхийн Монголчуудын MGL радиотой ТББ-тай хамтран ажиллах 2.332.440 төгрөгийн гэрээ байгуулан 1 сарын хугацаанд авлигын эсрэг радио зөвлөгөөг

бэлтгэн MGL радиогоор өдрийн 6 удаагийн давтамжтай нийт 185 удаа, лед дэлгэцээр 600 удаа, фээсбүүк хуудсаар 45 удаагийн давтамжтай мэдээллийг тус тус хүргэсэн орон нутгийн телевиз болон аймгийн цахим, пэйж хуудсууд, лед



дэлгэцээр дамжуулан нийт 65200 иргэнд хүргэж ажилласан байна.

**1.2.Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад тухай бүр дэмжлэг үзүүлэх хүрээнд:**

Аймгийн хэмжээнд АТГ-аас цахимаар зохион байгуулсан 4 удаагийн цахим сургалтад нийт 53 төрийн байгууллагын давхардсан тоогоор 789 албан тушаалтан хамрагдсан. Төлөвлөгөөт сургалтад 13



байгууллагын 475 төрийн албан хаагч иргэд цахим болон танхимын сургалтад хамрагдсан. Хууль тогтоомжийн сурталчилгааг орон нутгийн телевиз, аймгийн [www.bayankhongor.gov.mn](http://www.bayankhongor.gov.mn) цахим хуудас, хэлтсийн PAGE хуудас болон мэдээллийн самбараар сурталчлан, хялбаршуулсан гарын авлага бэлтгэж иргэд, төрийн байгууллагуудад түгээн ажиллаж байна.

**1.3.Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх ажлын хүрээнд:**

Тухайн оны төсвийн төсөл зэрэг хагас бүтэн жилээр оруулах мэдээллүүдийг хуулийн цаглабарт хугацаанд Шилэн дансанд байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтэд мэдээлж ажилласан.

Мөн аймгийн [www.bayankhongor.gov.mn](http://www.bayankhongor.gov.mn) цахим хуудасны шилэн данс цэсэнд тухайн жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, аудитын дүгнэлт, зөвлөмж, орон нутгийн хөгжлийн сан, болон холбогдох бусад мэдээллийг тогтмол байршуулж байна.

**1.4.Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах ажлын хүрээнд:**

Аймгийн Засаг даргын 2022 оны 06 сарын 08-ны байдлаар архины тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт ирүүлсэн 96 иргэнээс баримт бичгийн шаардлага хангасан 79 иргэний тусгай



зөвшөөрлийн хугацааг сунгаж, 15 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шинээр олгож 2 иргэний тусгай зөвшөөрлийн нэр өөрчилсөн байна.

Мөн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт бүхий өргөдлийн маягтыг [bayankhongor.gov.mn](http://bayankhongor.gov.mn) цахим хуудсанд байршуулсан.




Эрүүл мэндийн чиглэлийн байгууллагуудаас тус оны эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж үйл ажиллагааныхаа тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулсан 5, шинээр авсан 3, хаяг байршилд өөрчлөлт оруулсан 2, түдгэлзүүлсэн 1, хүчингүй болгосон 4 байна.

Боловсролын байгууллагуудаас энэ оны эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрлийн хугацааг шинээр болон сунгах тухай хүсэл ирүүлээгүй болно Бизнес эрхлэх орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухайд:

Орон нутагт бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, короновируст халдварт цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах зорилтын хүрээнд хуулиар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл авахыг шаардсанаас бусад бүх төрлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт, шаардлагад нийцүүлэн, зөвхөн татварын албанд бүртгүүлсний үндсэн дээр аймгийн нутаг дэвсгэрт чөлөөтэй эрхлэх нөхцөл, боломжийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс аймгийн хэмжээнд олгож байна.


**1.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах ажлын хүрээнд:**

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах төлөвлөгөөг мэдээллийн самбар, орон нутгийн Баянхонгор ТВ болон хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн. Мөн



[www.bayanhongor.gov.mn](http://www.bayanhongor.gov.mn) сайт болон шилэн данс, Төрийн худалдан авах ажиллагааны “tender.gov.mn, байгууллагын мэдээллийн самбарт байнга байршуулан мэдээлсэн.

Мөн Орон нутгийн өмчийн газар нь 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр 100%



амжилттай зохион байгуулсан. Нээлттэй зарлагдсан тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын “Зууны мэдээ” сонинд тухай бүр нийтлүүлж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем

tender.gov.mn-д байршуулан нийтэд ил тод, шуурхай зохион байгуулж байна.

Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn сайтын тендер шалгаруулалтын үр дүн гэсэн цэс болон байгууллагын самбар, шилэн дансанд тухай бүр оруулж ажиллаж байна.

Байгууллагын гадна байршуулсан самбар : Худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор төсөв, санхүү, тендерийн урилга бусад холбогдох мэдээллийг өөрийн мэдээллийн самбар, Төрийн худалдан авах ажиллагааны цахим сайт, Баянхонгор аймгийн албан ёсны




[www.bayanhongor.gov.mn](http://www.bayanhongor.gov.mn), “Баянхонгор ТВ” зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан олон нийтэд мэдээлж байна.



**1.6.Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах ажлын хүрээнд:**

**Хамтран ажиллах гэрээний хүрээнд:**

Нийгмийн хариуцлагын хүрээнд Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн авлигын талаарх мэдээллийг зорчигчдод сонсгож, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахаар хот хоорондын автобус үйлчилгээний байгууллагууд нэгдэн хамтран ажиллах гэрээ байгууллаа.



үзүүлдэг "Баянхонгор Тээвэрчин" ХХК, "Лотот" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан олон нийтэд хүргэхээр 1 сарын хугацаатай гэрээ байгуулан мэдээллийг түгээн ажиллаж байна.

**Хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд:**

Төрийн байгууллагуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, төсөл хөтөлбөр хариуцан ажилладаг мэргэжилтнүүдэд “Төрийн албан хаагчийн харилцаа ба ёс



зүй”, “Хандлага”, “Нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалт” сэдвүүдийн хүрээнд мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг АЗДТГ-ын Хуулт эрх зүйн хэлтэс BEST хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлэгч Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр зохион байгууллаа.

Тус сургалтын зорилго нь: Төрөөс ЖДҮ нарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн төсөл сонгон шалгаруулах, тус сангаас зээл олгохтой холбоотой хууль тогтоомжийн хүрээнд шийдвэр гаргах явцад төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж, шударга ёсыг эрхэмлэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид нийтийн эрх ашгийн төлөө ил тод нээлттэй байдлыг эрхэмлэн ажиллах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд оршиж байлаа.

**1.7.Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд:**

Иргэдэд нээлттэй ил тод, шударга байдлыг бий болгох зорилт тавин сул орон тооны зарыг

- Аймгийн [www.bayanhongor.gov.mn](http://www.bayanhongor.gov.mn) цахим хуудас
- Төрийн албаны зөвлөлийн [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) цахим хуудас
- [www.facebook.com/](http://www.facebook.com/) Баянхонгор аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл/ групп,
- Орон нутгийн 3 телевиз,
- [www.facebook.com](http://www.facebook.com/) /Нээлттэй засаг-Нэг Баянхонгор/ зэрэг цахим хуудсуудад мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

**Аймгийн засаг дарга Д.Мөнхсайхан 20 сумын засаг даргад хамтран ажиллах батламж олгон, авлигагүй ажиллах талаар баталгаа гаруулав:**

Аймгийн Удирдах ажилтны зөвлөгөөнийг АЗДТГ-аас 02-р сарын 28-ний өдөр зохион байгууллаа. Удирдах ажилтны нийт бүрэлдэхүүнтэй аймгийн удирдлагууд уулзалт хийсний даргаа Засаг дарга Д.Мөнхсайхан 20 сумын Засаг дарга нартай



Ажил орлоготой иргэн, Архигүй эрүүл өрх, Авлигагүй шударга төрийн төлөө хамтран ажиллах 10 зүйл бүхий үүргийг хүлээлгэсэн хоёр талын гарын үсэг бүхий батламжийг олголоо.

Мөн батламж, авлигагүй ажиллах баталгаанд тусгасан хүлээсэн үүргийн хэрэгжилтийг жилд хоёр удаа ЗДТГ-аас тогтмол шалгаж үнэлгээ өгөх юм.

Хэрэв Аймгийн Засаг дарга түүний Тамгын газраас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, албан үүргээ хангалтгүй биелүүлэх, төсвийн



хөрөнгийг үрэлгэн зарцуулах, архидан согтуурах, хууль зөрчин аливаа томилгоо хийх, иргэний язгуур эрхийг хөндөх, ёс суртахууны доголдол гаргах, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдох тохиолдолд Засаг даргын үүрэг ажлаас шууд татгалзаж зохих хууль тогтоомжийн дагуу шийтгэл хариуцлага хүлээлгэхээр заасан.

**1.8.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах ажлын хүрээнд:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 70440001 дугаарын утсаар, [www.bayanhongor.gov.mn](http://www.bayanhongor.gov.mn) вэб сайтаар, [info@bayankhongor.gov.mn](mailto:info@bayankhongor.gov.mn) цахим шуудангийн хаягаар, Засаг даргын Тамгын газрын байр болон төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн байранд байрлах санал авах хайрцгаар мөн аймгийг Засаг дарга долоо хоног бүрийн Пүрэв гарагт иргэдийг хүлээн авч уулзаж, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Өргөдөл, гомдол, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн бичгээр тус тус иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч байна. Энэ оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар нийт 157 өргөдөл ирснээс 112 гомдол хүсэлтийг хуулийн



хугацаанд шийдвэрлэн ажиллалаа.

**1.9.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бүүруулах ажлын хүрээнд:**

"Иргэдийн мэдэх эрхийг хэрэгжүүлье" нөлөөллийн арга хэмжээг аймгийн 6 суманд зохион байгуулж төрийн албан хаагч, иргэд, ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчдаас бүрдсэн 1036 хүнийг хамруулаад байна. Тус арга хэмжээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу "Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалт" сэдвээр 215 төрийн албан хаагчийг хамруулан авлигын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэн **Авлигатай тэмцэх газрын пэйж хуудас, АТГ-Олон нийтийн төв зэрэг албан ёсны хуудсуудад нэгдэхийг** уриалан 1020 төрийн албан хаагчийг нэгдүүлж 200 ширхэг **ТАТ, ТҮЛХ** хаалганы наалтыг тараан сурталчилж ажиллалаа.



Авилгатай тэмцэх газраас Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 03 сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулсан сургагч багш





бэлтгэх сургалтад АЗДТГ-ын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хариуцсан Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн хамрагдаж мэдлэг ойлголтоо сайжруулав.

Төрөөс иргэдэд олгодог бүх төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үнэ төлбөргүй хүргэх, төрийн байгууллагатай холбоотой гомдол саналыг цахим хэлбэрээр хүлээн авч иргэдэд хүргэж үйлчилгээг ойртуулах зорилгоор нэвтрүүлж байгаа “E-mongolia” программыг нэвтрүүлэн ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд “Дижитал Баянхонгор” арга хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Арга хэмжээг зохион байгуулснаар Баянхонгор аймгийн төрийн 31 үйлчилгээ “E mongolia” системд нэвтрээд байгаа бол цахим жишиг аймаг болох зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын үйлчилгээний цахим шилжилтүүд үргэлжлэн хийгдэж, хөгжүүлэлт явагдсаар байна.



Энэ үеэр Мобиком корпорациас улс орон даяар хэрэгжүүлсэн “Smart education 2” төсөлд бүтээл нь шалгарсан 60 хүүхдэд /22,0 сая төгрөгийн өртөг бүхий/ 60 ширхэг ухаалаг утас, Юнител групп “Аргун” төслийн хүрээндээ





байгалийн ухааны хичээлүүдийг хүүхдүүдэд маш ойлгомжтой бодитой шийдлээр үзүүлэн таниулах бичил лабораторийг Баянхонгор сумын Номундалай, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм, Соого сейкео сургуулиудад тус тус олголоо.

Цахим боловсрол олгох “Дижитал Баянхонгор” нээлттэй өдөрлөгт төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, банк санхүү, үүрэн холбооны операторуудын 46 байгууллага нэгдэн оролцож, иргэдэд өөрсдийн чиглэлээр бүх төрлийн мэдээлэл, лавлагаа, үйлчилгээ, зөвлөгөөг газар дээр нь шуурхай хүргэж ажилласан бол манай иргэд технологийн дэвшил, түүний хэрэглээ, үр ашгийн талаар тодорхой ойлголтууд, мэдээлэлтэй болсон



Аймгийн Засаг даргын Тамгын газар, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Баянхонгор аймгийн салбартай хамтран иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх “Хуульчийн Про Боно өдөр-2022” өдөрлөгийг 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж

хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл хүлээн авч зөвлөгөө өгөх, нотариатын үйлдэлтэй холбоотой зөвлөгөө, мэдээлэл, баримт бичгийн

НЭГЭЛЭЛЭН
ХАМТРААХ ОРГАНИЗАЦИ











## “ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨР-2022” ӨДӨРЛӨГ

2022.04.29

“ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨР-2022”

- ХУУЛЬ ЗҮЙН ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ЗӨВЛӨГӨӨ
- ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА
- ШҮҮХИЙН ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАГЧ ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВЧ ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ
- НАТОРИАТЫН ҮЙЛДЭЛ (ЭГЭЖ) АНГЫН ХУСААР ТӨӨРҮЙ МЭЛЭЭ
- ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ
- ТЭГТЭВЭР ТЭГТЭМЖ
- ЭРҮҮ ИРГЭНИЙ ШҮҮХИЙН ШИЙДЭЭР ГҮЙЦЭГТЭХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООСТОЙ ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, ӨРГӨДӨЛ ГОНДОЛ ХҮЛЭЭЖ АВАХ
- ГАДААД ПАССПОРТЫН ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ


Иргэн та 2022 оны дөрөвдүгээр сарын 29-ний өдрийн 10:00-13:00 цагийн хооронд Баянхонгор аймгийн Тэнгүжин театрын азаланд хүрэлцэн ирж бүх төрлийн хууль зүйн зөвлөгөөг ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ аваарай.



хуулбар үнэ төлбөргүй батлах, хүний эрхийн зөрчилтэй холбоотой зөвлөгөө, өргөдөл, гомдол хүлээж авах, эрүү, Иргэний Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар мэдээлэл, Нийгмийн даатгал, Хөдөлмөр халамжийн байгууллагаас олгодог тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой зөвлөгөө мэдээлэл гадаад паспортын захиалга хүлээн авах зэрэг үйлчилгээнүүдийг үнэ төлбөргүйгээр хүргэж ажиллалаа.

Иргэдийн мэдэх эрхийн хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын баруун жигүүрт байрлалтай "Нэг цонх"-ны үйлчилгээний төвийн зааланд "Шударга ёс хөгжил дэвшилд" нэртэй авлигын талаарх мэдээллийг түгээх, хүлээн авах самбар ажиллуулж мэдээллийг тогмол шинэчлэн ажиллаж байна. Тус 110 мэдээллийн самбарыг аймгийн Төрийн аудитын газар, Эрдэнэцогт сумын ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрууд гэх мэт 12 байгууллага тус тус шинээр хийлгэн байршуулсан бөгөөд бусад сум байгууллагууд хуучин самбартаа 110 дугаарын утас мэдээллийг байршуулан ажиллаж байна. Мөн тус самбарт иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцаг ажиллуулж байна. Он гарсаар тус хайрцагт авлигатай холбоотой санал, гомдол ирүүлээгүй үйлчилгээний талаар талархсан сэтгэгдэл 3 ирснийг тухай албан хаагчид хүлээлгэн өгч мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

ХЯНАСАН:  
ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

НЭГТГЭСЭН  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Ж.ЛХАМДУЛАМ

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны 06 дугаар сарын 08

Номгон

Д /д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Биелэлт
1	2	3	4	5
1	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>1.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;</p> <p>1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах;</p> <p>1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;</p>	<p>-Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх</p> <p>-Дэмжиж хамтран ажилласан байх -Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх</p> <p>-Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх -Авлигатай тэмцэх газраас</p>	<p>АТГ-аас ирүүлсэн телевизийн богино хэмжээний 14 шторк, хэвлэн олшруулах 6 төрлийн материалууд, ФМ, радиогийн 14 зөвлөгөө мэдээллийг сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж 59 байгууллагын 1630 төрийн албан хаагч, 3560 иргэдэд үзүүлж 1208 удаа олон нийтэд хуваалцсан байна. Мөн 73 групп, 61 пэйж хуудсанд байршуулсан. Мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 14 төрлийн 64 зурган мэдээлэл, инфографик 183 ширхэг, 3 төрлийн гарын авлага 1873 ширхгийг олшруулж 5 мянга гаруй иргэнд тарааж тус тус сурталчилсан байна.</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд хамгийн олон сонсогчтой дэлхийн Монголчуудын MGL радиотой ТББ-тай хамтран ажиллах 2.332.440 төгрөгийн гэрээ байгуулан 1 сарын хугацаанд авлигын эсрэг радио зөвлөгөөг бэлтгэн MGL радиогоор өдрийн 6 удаагийн давтамжтай нийт 185 удаа, лед дэлгэцээр 600 удаа, фэйсбүүк хуудсаар 45 удаагийн давтамжтай мэдээллийг тус тус хүргэсэн орон нутгийн телевиз болон аймгийн цахим, пэйж хуудсууд, лед дэлгэцээр дамжуулан нийт 65200 иргэнд хүргэж ажилласан.</p> <p>Иргэдийн мэдэх эрхийн хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын баруун жигүүрт байрлалтай “Нэг цонх”-ны үйлчилгээний төвийн зааланд “Шударга ёс хөгжил дэвшилд” нэртэй авлигын талаарх мэдээллийг түгээх, хүлээн авах самбар ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Тус 110 мэдээллийн</p>



1	2	3	4	5
			хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх	самбарыг аймгийн Төрийн аудитын газар, Эрдэнэцогт сумын ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрууд гэх мэт 12 байгууллага тус тус шинээр хийлгэн байршуулсан бөгөөд бусад сум байгууллагууд хуучин самбартаа 110 дугаарын утас мэдээллийг байршуулан ажиллаж байна. Мөн тус самбарт иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцаг ажиллуулж байна. Одоогоор тус хайрцагт авлигатай холбоотой санал, гомдол ирүүлээгүй мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг нараа АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	2.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлсэн байх;	-Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх	Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллах, авлига, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас Авлигатай тэмцэх газарт төрийн байгууллагуудын албан хаагчдыг соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулж, хамтран ажиллах талаар хүсэлт хүргүүлж, тус газраас 2022 оны 2 дугаар сарын 9-ний өдөр “Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдол”, “Авлигатай тэмцэх чиглэлээр соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын туршлага” сэдвийн хүрээнд төрийн захиргааны болон үйлчилгээний 53 байгууллагын дарга, удирдлага, төсөв санхүү хариуцсан нийт 307 албан тушаалтанд сургалт мэдээллийг хийж, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн.
		2.2.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх;	-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Аймгийн хэмжээнд АТГ-аас цахимаар зохион байгуулсан 4 удаагийн цахим сургалтад нийт 53 төрийн байгууллагын давхардсан тоогоор 789 албан тушаалтан хамрагдсан. Төлөвлөгөөт сургалтад 13 байгууллагын 475 төрийн албан хаагч иргэд цахим болон танхимын сургалтад хамрагдсан. Хууль тогтоомжийн сурталчилгааг орон нутгийн телевиз, аймгийн <a href="http://www.bayankhongor.gov.mn">www.bayankhongor.gov.mn</a> цахим хуудас, хэлтсийн PAGE хуудас болон мэдээллийн самбараар сурталчлан, хялбаршуулсан гарын авлага бэлтгэж иргэд, төрийн байгууллагуудад түгээн ажиллаж байна.

1	2	3	4	5
		<p>2.3.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залуус хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх;</p>	<p>-Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх, -Хамрагдсан хүүхэд залуус, иргэд тоо</p>	<p>Сургагч багш нь Авлигатай тэмцэх газраас 2022 оны 03 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулсан сургалтад хамрагдаж хөтөлбөрт тусгагдсан 15 хичээлийг иргэдэд заах эрхийг авсан. Сургагч багшаар дамжуулан Авлигатай тэмцэх газрын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2022 оны 02 дугаар сарын 15-наас 03 дугаар сарын 17-ны өдрийн хооронд хуваарийн дагуу 9 сэдвийн хүрээнд 47 байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний 789 албан хаагчдад сургалтыг цахимаар зохион байгуулж авлигын талаарх ойлголт мэдлэгийг нь сайжруулсан. "Иргэдийн мэдэх эрхийг хэрэгжүүлье" нөлөөллийн арга хэмжээг аймгийн 6 суманд зохион байгуулж төрийн албан хаагч, иргэд, ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчдаас бүрдсэн 1036 хүүхдийг хамруулсан. Тус арга хэмжээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу "Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалт" сэдвээр 287 төрийн албан хаагчийг хамруулан авлигын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэн <b>Авлигатай тэмцэх газрын пэйж хуудас, АТГ-Олон нийтийн төв</b> зэрэг албан ёсны хуудсуудад нэгдэхийг уриалан тат, түлх хаалганы наалт 200 ширхгийг, 3 төрлийн гарын авлага 150 ширхэг, 1 төрлийн зөвлөмжийг 50 ширхгийг хэвлүүлэн тараан сурталчилж ажиллалаа.</p> <p>Иргэдийн хамгийн ихээр үйлчлүүлж төрийн үйлчилгээ авдаг албан тушаалтнууд болох "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийн албан хаагчдад <b>"Ард түмэнд үйлчлэх зарчим ба авлига ашиг сонирхлын зөрчил", "Төрийн албан хаагчийн харилцаа ба ёс зүй"</b> сэдвээр 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр сургалт зохион байгуулсан. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд авлигын талаарх мэдээллийг зорчигчдод сонсгож, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахаар хот хоорондын автобус үйлчилгээний байгууллагууд болох "Баянхонгор Тээвэрчин" ХХК,</p>



1	2	3	4	5
				"Лотот" ХХК-уудтай хамтран ажиллах гэрээ байгуулан 1 сарын хугацаанд АТГ-аас ирүүлсэн болон орон нутагтаа бүтээсэн авлигыг үл тэвчих, энэ талаарх ойлголтыг нэмэгдүүлэх видео шторкуудыг хот хооронд зорчигч иргэдэд сонгож соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
3	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	3.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, 3.2.Мөрдөгчийн мэдэгдэл, 3.3.Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ;	-Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан ажлын хариу тайланг тухай бүр хүргүүлэн ажиллалаа.
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал; 4.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	-Уриа аянд нэгдсэн байдал  -Аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах	Аймгийн хэмжээнд "Авлигын эсрэг манлайлал сэдэвт" аяныг нэгж илийн хугацаатай өрнүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Хувийн хэвшлийн оролцоог хангах ажлын хүрээнд "Зөв зөвд шударга зөв" аяны хүрээнд хамгийн олон сонсогчтой дэлхийн Монголчуудын MGL радиотой ТББ-тай хамтран ажиллах 2.332.440 төгрөгийн гэрээ байгуулан хамтран ажилласан. Мөн авлигын талаарх мэдээллийг зорчигчдод сонгож, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахаар хот хоорондын автобус үйлчилгээний байгууллагууд болох "Баянхонгор Тээвэрчин" ХХК, "Лотот" ХХК-уудтай хамтран ажиллах гэрээ байгуулан 1 сарын хугацаатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ ава	5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх/ Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх,	-Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга	Төрөөс иргэдэд олгодог бүх төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үнэ төлбөргүй хүргэх, төрийн байгууллагатай холбоотой гомдол саналыг цахим хэлбэрээр хүлээн авч иргэдэд хүргэж үйлчилгээг ойртуулах зорилгоор нэвтрүүлж байгаа "E-mongolia" программыг нэвтрүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд "Дижитал Баянхонгор" арга хэмжээг 2022 оны

1	2	3	4	5
		эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	хэмжээг зохион байгуулсан байх	05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Энэ арга хэмжээг зохион байгуулснаар Баянхонгор аймгийн төрийн 31 үйлчилгээ "E mongolia" системд нэвтрээд байгаа бол цахим жишиг аймаг болох зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын үйлчилгээний цахим шилжилтүүд үргэлжлэн хийгдэж, хөгжүүлэлт явагдсаар байна
6	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	<p>-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;          -Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4          -Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах;          -Төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг үнэн зөв тайлагнан хагас жилд 06 дугаар сарын 10/ жилийн эцэст 12 дугаар сарын 10-ны дотор ирүүлэх</p>	-Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх	Аймгийн цахим хуудасны ил тод байдлыг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны А/11 дүгээр захирамжаар "Цахим хуудасны хөгжүүлэлт хийхэд хамтран ажиллаж хяналт тавих ажлын хэсэг"-ийг байгуулсан. Хөгжүүлэлт хийхээр санал ирүүлсэн 5 компаниас "Интеллигент техноложи солиушинс" ХХК сонгон 03 дугаар сард А/26 дугаарт гэрээ байгуулан аймгийн Засаг даргаар батлуулан тус компанитай хамтран ажиллаж байна. Гэрээнд заасан хугацаанд цахим хуудасны хөгжүүлэлтийн ажлыг хүлээн авч сум, байгууллагуудын цахим хөгжүүлэлт хариуцсан 64 албан хаагчдад сургалт зохион байгуулан, цаашид цахим хуудсаа хэрхэн хөгжүүлж ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн аймгийн төрийн байгууллагууд болон 20 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль", Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль"-ийн талаар мэдээлэл өгч танхимын сургалтыг нийт 104 албан хаагчид зохион байгуулж 19 сэдвийн хүрээнд 13 албан хаагч мэдээлэл хийж тэдний мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн.

ХЯНАСАН  
ДАРГА

НЭГТГЭСЭН:  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Д.ЭНХЖАРГАЛ

Ж.ЛХАМДУЛАМ





## ДҮГНЭХ ХУУДАС

2022 оны 06 дугаар сарын 08

Номгон

№	Зохион байгуулсан арга хэмжээ	Тоон үзүүлэлт	Хамруулсан хүний тоо
1.	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал;	АТГ-аас ирүүлсэн телевизийн богино хэмжээний 14 шторк, хэвлэн олшруулах 6 төрлийн материалууд, ФМ, радиогийн 14 зөвлөгөө мэдээллийг сум, байгууллагуудад олшруулан хүргүүлж 59 байгууллагын 1630 төрийн албан хаагч, 3560 иргэдэд үзүүлж 1208 удаа олон нийтэд хуваалцсан байна. Мөн 73 групп, 61 пэйж хуудсанд байршуулсан. Мэдээллийн самбарт авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан 14 төрлийн 64 зурган мэдээлэл, инфографик 183 ширхэг, 3 төрлийн гарын авлага 1873 ширхгийг олшруулж 5 мянга гаруй иргэнд тарааж тус тус сурталчилсан байна. Мөн дэлхийн Монголчуудын MGL радиотой ТББ-тай хамтран ажиллах 2.332.440 төгрөгийн гэрээ байгуулан 1 сарын хугацаанд авлигын эсрэг радио зөвлөгөөг бэлтгэн MGL радиогоор өдрийн 6 удаагийн давтамжтай нийт 185 удаа, лед дэлгэцээр 600 удаа, фэйсбүүк хуудсаар 45 удаагийн давтамжтай мэдээллийг тус тус хүргэсэн орон нутгийн телевиз болон аймгийн цахим, пэйж хуудсууд, лед дэлгэцээр дамжуулан нийт 65200 иргэнд хүргэж ажилласан	Авлигын эсрэг зөвлөгөөг MGL радиогоор 185 удаа, лед дэлгэцээр 600 удаа, фэйсбүүк хуудсаар 45 удаагийн давтамжтай давхардсан тоогоор нийт 65200 иргэнд хүргэж ажилласан
2.	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг) зэргээр сурталчилсан байдал;	"Иргэдийн мэдэх эрхийг хэрэгжүүлэе" нөлөөллийн арга хэмжээг аймгийн 6 суманд зохион байгуулж төрийн албан хаагч, иргэд, ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчдаас бүрдсэн 1036 хүнийг хамруулаад байна. Тус арга хэмжээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу "Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалт" сэдвээр 215 төрийн албан хаагчийг хамруулан авлигын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэн <b>Авлигатай тэмцэх газрын пэйж хуудас, АТГ-Олон нийтийн төв</b> зэрэг албан ёсны хуудсуудад нэгдэхийг уриалан 1020 төрийн албан хаагчийг нэгдүүлж 200 ширхэг <b>ТАТ, ТУЛХ</b> хаалганы наалтыг тараан сурталчилж ажиллалаа. Мөн фэйсбүүк хуудсаар 15 төрлийн мэдээг түгээж 700 хандалт, 143 удаа түгээн 1300 иргэн үзсэн 1036 төрийн албан хаагч дагасан байна	Фэйсбүүк хуудсаар 15 төрлийн мэдээг түгээж 700 хандалт, 143 удаа түгээн 1300 иргэн үзсэн 1036 төрийн албан хаагч дагасан
3.	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг дэмжиж ажилласан байдал;	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Зөв зөвд шударга зөв" аяны хүрээнд хамгийн олон сонсогчтой дэлхийн Монголчуудын MGL радиотой ТББ-тай хамтран ажиллах 2.332.440 төгрөгийн гэрээ байгуулан 1 сарын хугацаанд авлигын эсрэг радио зөвлөгөөг бэлтгэн MGL радиогоор өдрийн 6 удаагийн давтамжтай нийт 185 удаа, лед дэлгэцээр 600 удаа, фэйсбүүк хуудсаар 45 удаагийн давтамжтай мэдээллийг тус тус хүргэсэн орон нутгийн телевиз болон аймгийн цахим, пэйж хуудсууд, лед дэлгэцээр дамжуулан нийт 65200 иргэнд хүргэж ажилласан. АТГ-аас ирүүлсэн 10 төрлийн ном гарын авлага сэтгүүлийг 56 иргэд, төрийн албан хаагчид тараан ажилласан.	65200 иргэнд авлигын мэдээлэл хүргэж 10 төрлийн ном гарын авлага сэтгүүлийг 56 иргэд, төрийн албан хаагчид тараасан



1	2	3	4
4.	Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг орон нутаг, салбартаа зохион байгуулсан байдал;	Зөв зөвд шударга зөв аянд ажлыг хүрээнд аймгийн төвийн төрийн болон төрийн бус 60 байгууллага, 20 сумдад телевизийн богино хэмжээний 14 шторк, хэвлэн олшруулах 6 төрлийн материалуудын хамт хүргүүлж 5 мянга гаруй иргэдэд сурталчлан ажилласан.	5 мянга гаруй иргэнд сурталчилсан
5.	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах мэдээллийн булан, самбар тогтмол ажиллуулсан байдал;	Иргэдийн мэдэх эрхийн хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын баруун жигүүрт байрлалтай "Нэг цонх"-ны үйлчилгээний төвийн зааланд "Шударга ёс хөгжил дэвшилд" нэртэй авлигын талаарх мэдээллийг түгээх, хүлээн авах самбар ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Тус 110 мэдээллийн самбарыг аймгийн Төрийн аудитын газар, Эрдэнэцогт сумын ЗДТГ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрууд гэх мэт 12 байгууллага тус тус шинээр хийлгэн байршуулсан бөгөөд бусад сум байгууллагууд хуучин самбартаа 110 дугаарын утас мэдээллийг байршуулан ажиллаж байна. Мөн тус самбарт иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцаг ажиллуулж байна. Одоогоор тус хайрцагт авлигатай холбоотой санал, гомдол ирүүлээгүй мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.	110 мэдээллийн самбар шинээр бүтээлгэж тусгайлан авлигын мэдээлэл байршуулдаг болсон 12 байгууллага байна.
6.	Авлигын эсрэг сургалтын санал, захиалга өгсөн байдал;	АТГ-т авлигын эсрэг цахим сургалтын захиалга хүргүүлж 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр "Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалт", Авлигыг дарж чадсан олон улсын туршлага" сэдвээр зохион байгуулж 307 албан хаагч хамрагдсан.	Сургалтад 53 байгууллагын 307 албан тушаалтан оролцсон
7.	Авлигын эсрэг сургалтад шинээр томилогдсон албан хаагчаа хамруулсан байдал;	Авлигын эсрэг сургалтад шинээр томилогдсон 20 сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, Тамгын газрын дарга нарыг хамруулсан	54 албан тушаалаалан хамрагдсан
8.	Авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байдал;	АТГ-аас зохион байгуулсан 4 удаагийн цахим сургалтад нийт 90 төрийн байгууллагын давхардсан тоогоор 1142 албан тушаалтан хамрагдсан. Төлөвлөгөөт сургалтад 26 байгууллагын 980 төрийн албан хаагч иргэд цахим болон танхимын сургалтад хамрагдсан.	2122 албан хаагч, иргэд хамрагдсан
9.	Иргэд, олон нийт, хүүхэд залуучуудад зориулан авлигын эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байдал;	"Иргэдийн мэдэх эрхийг хэрэгжүүлбэ" нөлөөллийн арга хэмжээг аймгийн 6 суманд зохион байгуулж төрийн албан хаагч, иргэд, ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн 1036 сурагчдын авлигын талаарх ойлголт мэдлэгийг сайжруулсан.	1036 сурагч хамрагдсан
10.	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд арга хэмжээг зохион байгуулсан байдал;	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан ажлын хариу тайланг тухай бүр хүргүүлэн ажиллалаа.	Хариуг хугацаанд нь хүргүүлсэн
11.	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал;	Аймгийн хэмжээнд "Авлигын эсрэг манлайлал сэдэвт" аяныг нэгж илийн хугацаатай өрнүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Хувийн хэвшлийн оролцоог хангах ажлын хүрээнд "Зөв зөвд шударга зөв" аяны хүрээнд хамгийн олон сонсогчтой дэлхийн Монголчуудын MGL радиотой ТББ-тай хамтран ажиллах	3 төрийн бус байгууллагын оролцоог хангасан



	2	3	4
		2.332.440 төгрөгийн гэрээ байгуулан хамтран ажилласан. Мөн авлигын талаарх мэдээллийг зорчигчдод сонгож, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахаар хот хоорондын автобус үйлчилгээний байгууллагууд болох "Баянхонгор Тээвэрчин" ХХК, "Лотот" ХХК-уудтай хамтран ажиллах гэрээ байгуулан 1 сарын хугацаатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.	
12.	Авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр шинэ шийдэл, сайн туршлага, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байдал;	Төрөөс иргэдэд олгодог бүх төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үнэ төлбөргүй хүргэх, төрийн байгууллагатай холбоотой гомдол саналыг цахим хэлбэрээр хүлээн авч иргэдэд хүргэж үйлчилгээг ойртуулах зорилгоор нэвтрүүлж байгаа "E-mongolia" программыг нэвтрүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд "Дижитал Баянхонгор" арга хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгууллаа. Энэ арга хэмжээг зохион байгуулснаар Баянхонгор аймгийн төрийн 31 үйлчилгээ "E mongolia" системд нэвтрээд байгаа бол цахим жишиг аймаг болох зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын үйлчилгээний цахим шилжилтүүд үргэлжлэн хийгдэж, хөгжүүлэлт явагдсаар байна	Баянхонгор аймгийн төрийн 31 үйлчилгээ "E mongolia" системд нэвтрүүлсэн

6-дугаар зүйлийг дүгнэх хуудас				
/Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд зааснаар доорх мэдээллүүдийг цахим хуудас дээрээ байршуулж, иргэд үзэж, танилцах боломжоор хангах/				
д/д	Мэдээллүүд	Байршуулсан	Байршуулаагүй	Тайлбар
15	Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх, төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байдал	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
16	Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байдал;	Bayanhongor.gov.mn цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн санал хүсэлтэд хариу өгч ажиллаж байна.	-	-
17	Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
18	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
19	Дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
20	9.1.4.2.Жилийн эцсийн санхүүгийн тайлан /5 дүгээр сарын 1-ний дотор/	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
21	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /5 дүгээр сарын 1-ний дотор/	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
22	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
23	Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
24	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр,Хагас жилээр)	Eitimongolia цахим хуудсанд байршуулсан	-	-
25	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
26	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр)	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-



1	2	3	4	5
27	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээлэл;	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
28	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	tender.gov.mn-д байршуулсан	-	-
29	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга	tender.gov.mn-д байршуулсан	-	-
30	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
31	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
32	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн	Bayankhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
33	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр)	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
34	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр)	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
35	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /Бүтэн жил, сар бүр/ орон нутагт хамааралтай	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
36	Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Сар бүр) орон нутагт хамааралтай	<a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> -д тухай бүр байршуулан ажиллаж байна	-	-
37	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр)	-	-	-
38	Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
39	Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журам	Bayankhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-

1	2	3	4	5
40	Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа	Bayankhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
41	Ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээлэл	Байгууллагын цахим хаяг болон албан хаагчдын ажлын өрөөний үүдэнд ажилтнуудын хариуцсан ажил, чиг үүргийг байршуулсан	-	-
42	Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэл	Төрийн байгууллагуудын ил тод байдал сайжирсан	-	-
43	Ёс зүйн дүрэм	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
44	Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдал /тушаал, захирамж/	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
45	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, заавар	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
46	Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах	Bayanhongor.gov.mn хаягт тухай бүр байршуулсан	-	-
47	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр)	Тухай бүр байгууллагын дансанд бүртгэж мэдээлийн цахим хуудсанд бүртгэлжүүлэн ажиллаж байна.	-	-
48	Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 70440001 дугаарийн утсаар, <a href="http://www.bayanhongor.gov.mn">www.bayanhongor.gov.mn</a> вэб сайтаар, <a href="mailto:info@bayanhongor.gov.mn">info@bayanhongor.gov.mn</a> хаяг байгууллагын бичиг хэргээр дамжуулан хүлээн авч байна.	-	-
49	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь	Bayanhongor.gov.mn цахим хуудсанд иргэдэд ил тод байдлаар байршуулсан	-	-
50	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаарх мэдээлэл	Bayanhongor.gov.mn цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн санал хүсэлтэд хариу өгч ажиллаж байна.	-	-
51	Сул орон тооны зар /тухай бүр шинэчилсэн/	csc.gov.mn-д байгууллагуудаас ирсэн сул орон тооны мэдээллийг тухай бүр цахимд бүртгэн ТАЗ-д хүргүүлэн ажиллаж байна	-	-



1	2	3	4	5
52	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам	-	Хүний нөөцийн стратеги журам	Журамгүй
53	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр)	Хүний нөөцийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг сар бүр өөрчилж мөн бүрэлдэхүүн хөдөлгөөнийг <a href="https://hr.csc.gov.mt/">https://hr.csc.gov.mt/</a> цахим хаягт тогтмол бүртгэлжүүлдэг	-	-

ХЯНАСАН:  
ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

НЭГТГЭСЭН:  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

9007342 ГСТ7121

Ж.ЛХАМДУЛАМ

